



## **Нийцлийн аудитын тайлан**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 18, 28 ДУГААР  
ТОЙРОГТ ЯВАГДСАН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ НӨХӨН  
СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

**Үндэсний аудитын газар  
2022 он**

# **СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## **1. Аудитын нэр:**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойротг явагдсан Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянах.

## **2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт “Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 18, 28 дугаар тойротг явагдсан Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж нийтэд мэдээлнэ.

## **3. Аудитын зорилго:**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойротг явагдсан Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.

## **4. Аудитын хамрах хүрээ:**

Аудитад нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн бүрдүүлсэн орлого, зарлагын дэлгэрэнгүй тайлан, эрх бүхий байгууллагаас гаргасан лавлагаа мэдээлэл, арилжааны банкнуудаас ирүүлсэн нэр дэвшигчдийн хандивын дансны хуулга, сонгуулийн зардлын тайланд аудитын хуулийн этгээдийн гаргасан дүгнэлт зэрэг шаардлагатай эх сурвалжийг хамруулсан.

## **5. Арга зүй:**

Аудитын ажлыг гүйцэтгэхдээ Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын Их хурлын сонгуульд оролцож байгаа нам эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах” журмыг мөрдөж нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянан, холбогдох байгууллагууд болон аудит хийсэн хуулийн этгээдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан журам, заавар, аргачлалын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт гарган тайланг бэлтгэв.

## **6. Үндсэн мэдээлэл:**

Улсын Их Хурлын 2021 оны 61 дүгээр тогтоолоор сонгуулийн 18 дугаар тойротг, 2021 оны 40 дүгээр тогтоолоор 28 дугаар тойротг явуулах Улсын Их Хурлын гишүүний

нөхөн сонгуулийн санал авах өдрийг 2021 оны 10 дугаар сарын 10 байхаар товлон зарлаж, зохион байгуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явуулсан нөхөн сонгуульд нийт 8 нам, 1 эвслээс 14 нэр дэвшигч, мөн бие даан 2 иргэн нэр дэвшиж нийт 16 нэр дэвшигч оролцсон байна. Үүнд:

**Хүснэгт 1. Нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн судалгаа**

д/д	Нам, эвслийн нэр	Сонгуулийн тойрог		Нийт нэр дэвшигчийн тоо
		18 дугаар тойрог	28 дугаар тойрог	
1	Монгол ардын нам	1	1	2
2	Ардчилсан нам	1	1	2
3	Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам	1	1	2
4	Иргэний зориг ногоон нам	1	1	2
5	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам		1	1
6	Үнэн ба зөв нам		1	1
7	Дэлхийн монголчууд нам		1	1
8	Ард түмний олонхын засаглал	1	1	2
9	Зөв хүн электорат эвсэл		1	1
10	Бие даан нэр дэвшигч	1	1	2
	<b>Нийт</b>	<b>6</b>	<b>10</b>	<b>16</b>

Эх сурвалж: Нэр дэвшигчдийн ирүүлсэн тайлан.

Товлосон нөхөн сонгуульд сонгогчдын санал өгөх ирц тавь буюу түүнээс дээш хувьд хүрээгүй нийт 131 хэсгийн хороонд 2021 оны 10 дугаар сарын 16-ны өдөр нэмэлт санал хураалт явуулахаар Сонгуулийн Ерөнхий хорооны 105 дугаар тогтоол гарсан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэгт “Нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу нэр дэвшигчид аудитын хуулийн этгээдээр сонгуулийн зардлын тайландаа аудит хийлгэж, дүгнэлт гаргуулан, Үндэсний аудитын газар ирүүлсэн.

Нөхөн сонгуульд оролцсон 16 нэр дэвшигчийн дансанд нийт 1,136.4 сая төгрөгийн орлого төвлөрснөөс сонгуулийн үйл ажиллагааны зардалд 1,120.9 сая төгрөг зарцуулж, харилцах дансанд 15.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

## 7. Сонгуулийн зардлын дансны орлого, зардал:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9-д “Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан зардлын зарцуулалт, гүйцэтгэлийн тайланга ээлжит сонгуулийн жилийн 10 дугаар сарын 15-ны дотор, ээлжит бус нөхөн сонгуулийн тухайд санал хураалт дууссан өдрөөс хойш 90 хоногийн дотор тус тус гаргаж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа 16 нэр дэвшигч хугацаандаа ирүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг

санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын дээд байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу банкны нэр, дансны дугаарыг бүх нэр дэвшигчид бүртгүүлсэн байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаар нийт 1,136.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж тайлагнааснаас 1,134.9 сая төгрөгийн мөнгөн хандив, 1.5 сая төгрөгийн мөнгөн бус хандив байна. /Хавсралт №1/

**Хүснэгт 2. Нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн орлогын нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Орлого				Нийт	
	Мөнгөн хандив		Мөнгөн бус хандив			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	1	53.6			1	53.6
Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	5	11.8			5	11.8
Хуулийн этгээдийн хандив	22	241.7			22	241.7
Иргэний хандив	601	827.8	1	1.5	602	829.3
<b>Дүн</b>	<b>629</b>	<b>1,134.9</b>	<b>1</b>	<b>1.5</b>	<b>630</b>	<b>1,136.4</b>

Эх сурвалж: Нэр дэвшигчдийн ирүүлсэн тайлан.

Зөв хүн электорат эвслээс 53.6 сая төгрөгийн хөрөнгийг нэр дэвшигчийн дансанд шилжүүлж нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгөөр тайлагнажээ. Бусад намуудаас нэр дэвшигчийн сонгуулийн зардалд зориулан мөнгөн хөрөнгө зарцуулаагүйгээр тайлагнасан байна.

Шударга иргэдийн нэгдсэн эвсэл, Үнэн ба зөв нам, Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам, Иргэний зориг ногоон нам, Ард түмний олонхын засаглал намуудаас 5 нэр дэвшигч сонгуулийн зардалд зориулан өөрийн хөрөнгөнөөс 11.8 сая төгрөг оруулсан байна.

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагаанд нийт 1,120.9 сая төгрөг зарцуулснаас хуульд заасан сонгуулийн зардалд 1,110.9 сая, бусад зардалд 10.0 сая төгрөг зарцуулжээ. /Хавсралт №2/

**Хүснэгт 3. Нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Зардлын ангилаал		Мөнгөн дүн
<b>Нийт зардлын дүн</b>		1,120.9
<b>2.1 Сонгуулийн зардал</b>		1,110.9
	2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	181.3
	2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	37.4
	2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	5.2
	2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	4.1
	2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	797.0
	2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	57.0
	2.1.7 цахим орчин ашиглах зардал	27.6

	2.1.8 өдөр тутмын болон бусад сонин, сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	1.3
2.2	Бусад зардал	10.0

Эх сурвалж: Нэр дэвшигчдийн ирүүлсэн тайлан.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/23 дугаар тушаалаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосныг 16 нэр дэвшигч хэтрүүлээгүй байна.

## 8. Хуулиар зөвшөөрөөгүй хандив:

Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй зэрэг 196 иргэний 212.2 сая төгрөгийн хуулиар зөвшөөрөөгүй хандив тайлагнаасаас 159 иргэний 210.9 сая төгрөгийн хандивыг буцааж, 36 иргэний 1.3 сая төгрөгийн хандивыг улсын орлого болгоогүй байна.

## 9. Сонгуулийн зардлын тайланда хийсэн аудитын ирүүлэлт:

Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцсон нам, эвслүүд зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан бөгөөд тайланг үнэн зөв, иж бүрэн илэрхийлсэн гэсэн 16 дүгнэлт гарсан байна.

Аудитын хуулийн этгээд нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаалаар баталсан журмын дагуу Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланда аудит хийж баталгаажуулсныг Үндэсний аудитын газар дахин хянаж, аудитын явцад нийт 457.0 сая төгрөгийн тайлагналын алдааг залруулсан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5."Буцах хаяг нь тодорхойгүй хандивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ" гэсэн заалтыг зөрчиж нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу 36 иргэний 1.3 сая төгрөгийн хандивыг зарцуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-д "Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ" гэж заасны дагуу 5 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны хуулгыг ирүүлж, 11 нэр дэвшигчийн дансны хуулгыг дараах банкнууд ирүүлээгүй байна. Үүнд:

- ХААН банк 10 нэр дэвшигчийн,
- Төрийн банк 1 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны хуулга ирүүлээгүй.

## 10. Аудитын дүгнэлт

Аудитын зарим хуулийн этгээдүүд аудитын горим, сорилыг бүрэн хэрэгжүүлж, хангалттай, зохицтой нотлох баримтыг үндэслэн зардлын тайланг баталгаажуулах талаар дутагдалтай байна.

Арилжааны банкнууд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

**Аудитын зөвлөмж:**

**Сангийн сайдад:**

1. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд заасны дагуу нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны хуулга ирүүлээгүй арилжааны банкнууд болон хуулиар зөвшөөрөөгүй орлогыг зарцуулсан нэр дэвшигчдэд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд заасны дагуу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах;

**Аудитын хуулийн этгээдүүдэд:**

2. Аудитын Олон Улсын Стандартыг чандлан мөрдөж, ёс зүйг баримтлан, аудитын горим, сорилыг бүрэн хэрэгжүүлж, хангалттай, зохистой нотлох баримтыг үндэслэн зөв баталгаажуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх;

Хавсралт №1

УИХ-ЫН ГИШҮҮНИЙ 18, 28 ДУГААР ТОЙРОГТ ЯВАГДСАН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН  
ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

Д/д	Тойргийн дугаар	Нам, эвсэл	Нэр дэвшигч	Нийт орлогын дүн	Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив		Иргэний өгсөн нийт хандив			
							тоо	Мөнгөн хандив	тоо	Мөнгөн хандив	тоо	Мөнгөн бус хандив
			<b>Нийт</b>	<b>1,136,459.2</b>	<b>53,630.0</b>	<b>11,810.3</b>	<b>22</b>	<b>241,700.0</b>	<b>601</b>	<b>827,818.9</b>	<b>1</b>	<b>1,500.0</b>
1	ХЭ-18	Монгол ардын нам	Ц.Идэрбат	196,840.0						58	196,840.0	
2	ХЭ-18	Ардчилсан нам	Б.Гарамгайбаатар	86,850.0						52	86,850.0	
3	ХЭ-18	Шударга иргээдийн нэгдсэн эвсэл нам	Д.Баатаржав	270.0						3	270	
4	ХЭ-18	Иргэний зориг ногоон нам	А.Бархүү	7,200.0		4,330.0				14	2,870.0	
5	ХЭ-18	Ард түмний олонхын засаглал	Д.Чулуунбат	300.3		0.3				5	300.0	
6	ХЭ-18	Бие даан нэр дэвшигч	М.Чингисхаан	399.0						20	399.0	
7	СХД-28	Монгол ардын нам	Э.Батшугар	350,500.0			8	130,000.0	55	220,500.0		
8	СХД-28	Ардчилсан нам	Э.Бат-үүл	33,832.3			1	2,000.0	93	31,832.3		
9	СХД-28	Шударга иргээдийн нэгдсэн эвсэл нам	Ц.Гантулга	31,610.0		5,000.0				18	26,610.0	
10	СХД-28	Иргэний зориг ногоон нам	Ш.Гантулга	3,233.5						47	3,233.5	
11	СХД-28	Ард түмний олонхын засаглал	А.Батдорж	300.0						1	300	
12	СХД-28	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	Ш.Төмөрсүх	13,300.0		2,180.0				15	11,120.0	
13	СХД-28	Үнэн ба зөв нам	А.Отгонбаатар	2,720.0		300.0				18	920.0	1
14	СХД-28	Дэлхийн монголчууд нам	Л.Цог	700.0			2	700.0				
15	СХД-28	Зөв хүн электорат эвсэл	Б.Найдалаа	400,629.7	53,630.0		11	109,000.0	186	237,999.7		
16	СХД-28	Бие даан нэр дэвшигч	Х.Бат-Ялалт	7,774.4						16	7,774.4	

Хавсралт №2

УИХ-ЫН ГИШҮҮНИЙ 18, 28 ДУГААР ТОЙРОГТ ЯВАГДСАН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

Д/д	Тойргийн дугаар	Нам, эвсэл	Нэр дэвшигч	Нийт зардлын дүн	Сонгуулийн зардал	Сонгуулийн зардлын ангилал							Бусад зардал	
						Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгочдод тараах	Нийтийн эзэмшилийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байршуулах зардал	Намын далбааг дадамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	Цахим орчин ашиглах зардал	Өдөр тутмын болон бусад сонин сэтуулд материал нийтлүүлэх зардал	
<b>Нийт</b>				<b>1,120,988.8</b>	<b>1,110,958.1</b>	<b>181,333.5</b>	<b>37,380.9</b>	<b>5,219.5</b>	<b>4,106.8</b>	<b>796,963.6</b>	<b>57,045.5</b>	<b>27,648.3</b>	<b>1,260.0</b>	<b>10,030.7</b>
1	ХЭ-18	Монгол ардын нам	Ц.Идэрбат	196,819.0	195,750.0	52,100.0				135,380.0	3,000.0	5,270.0		1,069.0
2	ХЭ-18	Ардчилсан нам	Б.Гарамгайбаатар	86,850.0	80,057.0	10,935.2	2,498.1			57,373.7	9,250.0			6,793.0
3	ХЭ-18	Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам	Д.Баатаржав	269.4	269.4					269.4				
4	ХЭ-18	Иргэний зориг ногоон нам	А.Бархүү	7,200.0	7,196.8	1,920.0	1,415.0	523.0	890.0	2,088.8			360.0	3.2
5	ХЭ-18	Ард түмний олонхын засаглал	Д.Чулуунбат	300.3	181.6					81.6			100.0	118.7
6	ХЭ-18	Бие даан нэр дэвшигч	М.Чингисхаан	399.0	399.0					399.0				
7	СХД-28	Монгол ардын нам	Э.Батшугар	350,438.7	349,428.2	14,925.4			2,111.8	331,868.5		522.5		1,010.5
8	СХД-28	Ардчилсан нам	Э.Бат-үүл	33,804.2	33,799.5	17,920.0		350.0		11,379.5		3,350.0	800.0	4.7
9	СХД-28	Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам	Ц.Гантулга	31,610.0	31,608.0	26,108.0					5,500.0			2.0
10	СХД-28	Иргэний зориг ногоон нам	Ш.Гантулга	3,226.7	3,226.7	966.7	350.0			1,910.0				
11	СХД-28	Ард түмний олонхын засаглал	А.Батдорж	300.0	85.0					85.0				215.0
12	СХД-28	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	Ш.Төмөрсүх	13,300.0	13,297.2	3,976.9				3,651.0	4,600.0	1,069.3		2.8
13	СХД-28	Үнэн ба зөв нам	А.Отгонбаатар	2,702.3	2,700.0	500.0	1,500.0			700.0				2.3
14	СХД-28	Дэлхийн монголчууд нам	Л.Цог	699.6	699.0		600.0					99.0		0.6
15	СХД-28	Зөв хүн электорат эвсэл	Б.Найдалаа	387,024.1	386,218.2	48,538.8	31,017.8	4,346.5	1,105.0	249,177.1	34,695.5	17,337.5		805.9
16	СХД-28	Бие даан нэр дэвшигч	Х.Бат-Ялалт	6,045.5	6,042.5	3,442.5				2,600.0				3.0

